

11-11 төв

Д/д	Дугаар	Төрөл	Хугацаа	Холбогдох утас, нэр	Санал, хүсэлт, гомдол	Хариуцах газар	Биелэлт
1	№0000354559	Гомдол	2023.01.06 13:59	С.Батамгалан 89848978	Монголын төмөр замын төрийн өмчит хувьцаат компани нь цахилгааны мэргэжилтний ажлын байран дээрээ ажилчин авна гэсэн зар тавьсан байсан. Би 11 дүгээр сард ажилд орох хүсэлтээ өгсөн. Гэтэл надад хариу өгөхгүй байсан. Гэтэл тэтгэвэртээ гарсан ажилчид нь өндөр насны тэтгэвэртээ суухгүйгээр ажиллаад залуу боловсон хүчээ хойш суулгаж байна. Энэ асуудлыг холбогдох байгууллагад нь уламжилж өгөн үү.	МТЗ	Манай компани цахилгааны мэргэжилтэн ажилд авах зар 11 сард огт зарлаагүй тул тухайн иргэн "УБТЗ" ХНН-тай андуурсан бололтой. Дийлэнх иргэд "УБТЗ" ХНН-ийг хуучин нэршлээр "Монголын төмөр зам" гэж хэвшсэнтэй холбоотой дээрх андуурал гарсан гэж үзэж байна. Тус компанийн зүгээс Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн хүрээнд цахилгаан эрчим хүчний мэргэжлийн инженер техникийн ажилтнуудыг шалгаруулах ажлын байрны зарыг 2022 оны 04 сард компанийн албан ёсны вэбсайтаар дамжуулан зарлаж байсан болно. Түүнээс хойш цахилгаан эрчим хүчний ажилтны ажлын байрны зар нийтлээгүй болно.
2		Гомдол	2022.12.15	Номин-Эрдэнэ 90195519	Хонгконг Top Star Компани 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр ачааны вагоны түрээсийн гэрээ байгуулсан. "Монголын төмөр зам" ТӨХК нь эргээд ямар ч хариу өгөөгүй. Угсаар асуухад манай вагон мидлинг тээвэрт явж байгаа. Бид нар мэдэхгүй, ЗТХЯ-наас асуу гэсэн хариу өгсөн. Бид нарт вагон явахгүй талаар ямар ч хариу, тушаал шийдвэр эргэж танилцуулаагүй. Мэдээлэл өгөөгүй. Гомдолтой байна.	МТЗ	Гомдлын дагуу Хонгконг Top Star Компани-д хариу албан тоот хүргэж, угсаар холбогдсон. "МТЗ" ТӨХК нь Засгийн газрын шийдвэрийн дагуу 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн мидлинг тээвэрлэлтийг эхлүүлсэн бөгөөд тээвэрлэлт өнөөдрийг хүртэл тасралтгүй үргэлжилж байна. Энэ тухай 2 тал МТЗ ТӨХК-ийн байранд уулзах үед мэдэгдсэн. Одоогоор компанийн эзэмшлийн бүх ачааны вагон мидлинг тээвэрлэлтэд явж байгаа тул вагон суларсан тохиолдолд түрээсийн үйлчилгээ үзүүлэх боломжтой болох юм.
3	№0000325612	Хүсэлт	2022.11.28 10:04	99091537	Цэцэрлэгийн насны хүүхдүүдийг амраачхаад, эцэг эхчүүдийг нь амраана гэсэн байгаа ч бодит байдал дээрээ энэ нь хэрэгжихгүй байна. Хажуу айлын хүн надад хүүхдээ үлдээгээд явлаа. Монголын төмөр замын байгууллага нь ажилтнаа амраахгүйгээс болоод ийм зүйл болж байна. Гаргасан тушаал шийдвэр нь байгууллага дээрээ хэрэгжихгүй байна. Энэ асуудлыг холбогдох газарт нь уламжлан шийдвэрлэж, иргэнд яаралтай хариу өгнө үү.	МТЗ	Нийслэлийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 22-ны захирмжийн хүрээнд 12 хүртэлх насны хүүхэдтэй эмэгтэй ажилтнуудыг цахимаар ажиллуулж, дотоод зохион байгуулалт хийхийг бүх газар албадуудын дарга нарт 2022 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Захиргаа, удирдлагын газраас чиглэл болгосон. Үүнтэй холбоотойгоор газар, албадан ажилтнуудаас Захиргаа, хүний нөөцийн албанд ямар нэгэн гомдол ирүүлээгүй болно.
4	№0000309417	Гомдол	2022.11.04 09:50	89285808	Миний нөхөр Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Монголын төмөр зам өртөөнд ажилдаг юм. Тус байгууллага нь хөдөлмөрийн тухай хууль дүрмийг зөрчдөг. 20 хоног гарч 10 хоног амраах хуваариар ажиллуулдаг. Хотоос хөдөө ажил руугаа явж байгаа хугацааг ажилсан хугацаанд тооцох ёстой хууль дүрмийг тооцохгүй зөрчдөг. Миний нөхөр саяхан нуруу нь татаж гэмтэж 14 хоногийн акт авсан. Тус байгууллага листийн мөнгийг олгоогүй. Нягтлангаас асуухад манай дансанд таны нөхрийн листийн мөнгө орж ирээгүй гэсэн. Гэтэл нийгмийн даатгалгаас лавлаж асуухад миний нөхрийн нэр дээр листийн мөнгө орсон байсан. Энэ байгууллагын цалингийн нягтлан чамаар ажлаа заалгахгүй авгай минь гэж ёс зүйгүй бүдүүлэг харьцсан. Энэ нягтлангийн буруутай үйлдлээс болж листийн мөнгөө авч чадахгүй хохироод байж байна. Ороогүй гэж худал хэлж зөндөө явуулаад орсон гэдгийг нь батлахад тэгээд ядаг юм гэж үл тоож харьцсан. Энэ асуудлын талаар ерөнхий нягтланд нь хэлсэн боловч ямар ч арга хэмжээ аваагүй. Энэ асуудлыг холбогдох газарт нь уламжилж, арга хэмжээ авч өгнө үү.	МТЗ	Уг ажилтан листний мөнгө орсон эсэх талаар лавлаж асууж байсан. Тухайн үед НД сангаас манай компани руу ажилтаны листны мөнгө орж ирээгүй мөн анхныгийн хуудас баталгаажиж ирээгүй байсан. НД сангаас мөнгө хэрхэн орж ирдэг, орж ирсний дараа яаж олгох талаар хэд хэдэн удаа тайлбарлаж өгсөн. Хэрэв листны мөнгө нь орж ирвэл сарын сүүл цалин дээр олгож өгнө гэсэн тайлбарыг хэлж байсан. Тайлбарлаж хэлсэн ёсоор тухайн ажилтаны листны мөнгийг сарын сүүл цалинд /2022.11.25/ олгогдсон болно.